



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
РЕКТОРЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/76

Улаанбаатар хот

“Монгол Улсын их сургуульд суралцагчдад  
тэтгэлэг олгох ерөнхий журам”-ыг  
шинэчлэн батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.1.2, 31.1.12, 31.1.13. дахь заалт, МУИС-ийн дүрмийн 5.4.1, 5.4.8.5, 5.4.8.9, 8.5.4 дэх хэсэг, МУИС-ийн Ректорын зөвлөлийн хурлын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын их сургуульд суралцагчдад тэтгэлэг олгох ерөнхий журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “МУИС-ийн нэрэмжит тэтгэлгийн журам”-ыг 2 дугаар хавсралтаар, “Ц.Дамдинсүрэн, Ш.Лувсанвандан, Б.Ринчен нарын нэрэмжит тэтгэлэг”-ийг 3 дугаар хавсралтаар, “МУИС-ийн докторант багшид тэтгэлэг олгох журам”-ыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. “Монгол Улсын их сургуульд суралцагчдад тэтгэлэг олгох ерөнхий журам”-ыг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3. “Монгол Улсын их сургуульд суралцагчдад тэтгэлэг олгох ерөнхий журам” шинэчлэн батлагдсантай холбогдуулан МУИС-ийн захирлын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/171 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор (Д.Заяабаатар), бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирлууд, алба нэгжийн удирдлагуудад даалгасугай.

РЕКТОР



Б.ОЧИРХУЯГ

D: tushaal\_2025

1425060676

Ректорын 2025 оны ...02 дугаар сарын 13-ны  
өдрийн А/76 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДАД  
ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЕРӨНХИЙ ЖУРАМ



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Монгол Улсын их сургуулийн (цаашид МУИС гэх) суралцагчдын амжилттай суралцах, судалгааны ажилд үр дүнтэй оролцох, эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэх, шилдэг элсэгчдийг дэмжин урамшуулах зорилгоор МУИС-ийн болон гадаад, дотоодын байгууллага, сан, төгсөгч, хувь хүний нэрэмжит тэтгэлэг олгох үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. МУИС-ийн бус санхүүжилтийн эх үүсвэртэй тэтгэлэг олгох үйл ажиллагааг тухайн байгууллагын тэтгэлэг олгох журам, МУИС-тай байгуулсан гэрээ, харилцан ойлголцлын санамж бичигт заасны дагуу зохион байгуулж болно.
- 1.3. Энэхүү журам нь хоёрдогч бакалаврын хөтөлбөрт суралцагчид хамаарахгүй.
- 1.4. Тэтгэлгийг суралцагчийн сургалтын төлбөрийг хөнгөлөх, судалгаа, амьжиргааны зардлыг дэмжих зорилгоор буцалтгүй тусламж хэлбэрээр олгоно.

ХОЁР. ТЭТГЭЛГИЙН ТӨРЛҮҮД

- 2.1. МУИС-ийн суралцагчдад олгох тэтгэлэг нь дараах төрлүүдээс бүрдэнэ. Үүнд:
  - 2.1.1. МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг,
  - 2.1.2. Докторын сургалтад суралцаж буй МУИС-ийн багшид олгох тэтгэлэг,
  - 2.1.3. Сургалт, судалгааны туслахаар ажиллуулах тэтгэлэг,
  - 2.1.4. МУИС-ийн бус эх үүсвэрээс санхүүжилт бүхий МУИС-ийн профессор багшийн судалгааны төслөөс олгох тэтгэлэг,
  - 2.1.5. МУИС-ийн бүрэлдэхүүн/салбар сургуулийн тэтгэлэг,
  - 2.1.6. Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэг
  - 2.1.7. Гадаад, дотоодын байгууллага, сан, төгсөгч, хувь хүний нэрэмжит тэтгэлэг
- 2.2. МУИС-ийн нэрэмжит тэтгэлгийг тухайн хичээлийн жилд бакалаврын өдрийн хөтөлбөрт элссэн шилдэг элсэгч, ахисан түвшний хөтөлбөрт элссэн гадаад улсын харьяат, хувийн төлбөрөөр суралцагч монгол угсаатанд олгоно.
- 2.3. МУИС-ийн докторын хөтөлбөрт амжилттай суралцаж буй үндсэн багшид докторын сургалтын тэтгэлэг олгоно.
- 2.4. Ахисан түвшний суралцагчдын судалгаа хийх, суралцах үйл ажиллагааг дэмжих болон мэргэшил, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор сургалт, судалгааны туслахын тэтгэлгийг олгоно.
- 2.5. МУИС-ийн бус эх үүсвэрээс санхүүжилт бүхий МУИС-ийн профессор багшийн судалгааны төслөөс суралцагчдад тэтгэлэг олгож болно.
- 2.6. Бүрэлдэхүүн/салбар сургууль нь шилдэг суралцагчийг дэмжих зорилгоор

тэтгэлэг олгож болох бөгөөд МУИС-ийн нэрэмжит тэтгэлэгтэй давхардуулахгүй.

- 2.7. Монгол улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, олон улсад өрсөлдөх мэдлэг чадвартай, нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмрээ оруулах, эх оронч шилдэг мэргэжилтэн, манлайлагчийг бэлтгэх зорилгоор дотоодын болон гадаадын сургалтын байгууллагад тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр дээд боловсрол эзэмших суралцагчид Засгийн газрын тэтгэлэг олгоно.
- 2.8. Тэтгэлэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэг, удирдамжийг МУИС-ийн ректорын тушаалаар батална.
- 2.9. Сургалтын төлбөрийн 12 багц цагтай тэнцэх хэмжээний тэтгэлэг авсан суралцагчид тэтгэлгийг давхардуулж олгохгүй. Үүнд "МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг"-ийн олимпиад нөхцөлөөр болон ЭЕШ-ийн өндөр үнэлгээгээр элссэн шилдэг элсэгчийн тэтгэлэг хамаарахгүй.

#### ГУРАВ. СУРАЛЦАГЧИД ТАВИХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

- 3.1. Тэтгэлгийн шалгаруулалтад нэр дэвших суралцагч нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 3.1.1. МУИС-ийн идэвхтэй төлөвийн суралцагч байх,
  - 3.1.2. Сурлагын болон эрдэм шинжилгээний ажлын амжилт гаргасан байх,
  - 3.1.3. Тэтгэлгийн нөхцөл, шаардлагыг хангасан байх,
  - 3.1.4. МУИС-ийн дүрэм, журмыг зөрчиж сахилгын болон ёс зүйн шийтгэл хүлээж байгаагүй байх.

#### ДӨРӨВ. ТЭТГЭЛЭГ ЗАРЛАХ, МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ, БҮРТГЭХ

- 4.1. Материал хүлээн авах эцсийн хугацаанаас 20-оос доошгүй хоногийн өмнө холбогдох нэгж МУИС-ийн цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр тэтгэлгийн зарыг түгээсэн байна.
- 4.2. Энэ журмын 3 дугаар бүлэгт заасан нийтлэг шаардлагыг хангасан суралцагч 4.3.-д заасан материалыг бүрдүүлэн цахимаар бүртгүүлнэ. Эх материалыг заасан хугацаанд, холбогдох нэгжид хүлээлгэн өгснөөр бүртгэл баталгаажна.
- 4.3. Тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргагч дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
  - 4.3.1. Суралцагчийн талаарх мэдээллийг агуулсан тэтгэлгийн анкет,
  - 4.3.2. Сурлагын дүнгийн дэлгэрэнгүй (Оюутны бүртгэл хариуцсан нэгж тодорхойлох). Тухайн тэтгэлэгт тохирсон амжилтыг илэрхийлсэн баримт бичиг, нотолгоо, түүний хуулбар,
  - 4.3.3. Мэргэжлийн профессор багшийн тодорхойлолт (шаардлагатай нөхцөлд),
  - 4.3.4. Тэнхим, бүрэлдэхүүн/салбар сургуулийн тодорхойлолт (шаардлагатай нөхцөлд),
  - 4.3.5. Бусад (тэтгэлгийн санхүүжүүлэгч байгууллага болон төрөл, нөхцөлөөс хамаарч бүрдүүлэх нэмэлт материал),
  - 4.3.6. Нийгмийн идэвх оролцоог дүгнэсэн тодорхойлолт, бусад гэрээ.
- 4.4. Тэтгэлэгт хүсэлт гаргагч нь мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах бөгөөд

бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд тэтгэлгийн сонгон шалгаруулалтаас хасна.

- 4.5. Холбогдох нэгж нь бичиг баримтын бүрдүүлэлт, тэтгэлгийн болзол шаардлагыг хангасан материалыг хүлээн авна.
- 4.6. Тэтгэлэгтэй холбогдолтой мэдээллийг нээлттэй, ил тод байлгаж, МУИС-ийн хичээлийн жилийн тайланд тусгана.



#### ТАВ. СУРАЛЦАГЧДЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

- 5.1. Тэтгэлэгт хамрагдах суралцагчийг сонгон шалгаруулах, анхан болон эцсийн шатны шалгаруулалтын материалыг санхүүжүүлэгч байгууллагад хүргүүлэх асуудлыг холбогдох нэгж хариуцан зохион байгуулна.
- 5.2. МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг болон гадаад, дотоодын байгууллага сан, төгсөгч, хувь хүний тэтгэлгийн сонгон шалгаруулалт явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг МУИС-ийн ректорын тушаалаар батална. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын дүн, бусад материалыг холбогдох нэгжид хүргүүлнэ.
- 5.3. Гадаад, дотоодын байгууллага, сан, төгсөгч, хувь хүний нэрэмжит тэтгэлгийн шалгаруулалтын ажлын хэсэгт тэтгэлэг олгогч талын төлөөллийг оролцуулж болно.
- 5.4. Ажлын хэсэг суралцагчдын сурлагын амжилтыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээний ажил хийх, авьяас чадварыг хөгжүүлэх хүрээнд шударга өрсөлдөөний зарчмыг баримтлан ажиллана.
- 5.5. Ажлын хэсэг шаардлагатай тохиолдолд тэтгэлэгт хүсэлт гаргагчтай ярилцлага хийж болно.
- 5.6. Тэтгэлэгт ирүүлсэн материалыг буцаан олгохгүй бөгөөд тэнцээгүй суралцагчдын материалыг нэг сарын турш хадгална.

#### ЗУРГАА. ТЭТГЭЛЭГ ОЛГОХ, БАТЛАМЖ ГАРДУУЛАХ

- 6.1. Холбогдох нэгж нь тэтгэлгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн суралцагчдад шалгаруулалтын дүнг мэдээлж, мэдээллийг МУИС-ийн цахим хуудсанд байршуулна.
- 6.2. МУИС-ийн нэрэмжит тэтгэлгийн батламжийг хичээлийн жилийн нээлтийн ёслол эсвэл оюутны эрхийн өдрөөр гардуулна.
- 6.3. Бусад байгууллага, сан, төгсөгч, хувь хүмүүсийн нэрэмжит тэтгэлгийг гардуулах ёслолын ажиллагааг тухайн байгууллага, хувь хүмүүстэй байгуулсан гэрээ, харилцан ойлголцлын санамж бичигт заасны дагуу зохион байгуулна.
- 6.4. Суралцагчдад тэтгэлэг олгох тухай ректорын тушаалыг холбогдох нэгж боловсруулах бөгөөд тушаалд оюутны овог, нэр, бүрэлдэхүүн сургууль, бүртгэлийн дугаар, тухайн улиралд сонгон судлах багц цагийн мэдээллийг тусгана.
- 6.5. Тэтгэлгийг суралцагчийн сургалтын төлбөрөөс бусад зориулалтаар ашиглахгүй бөгөөд харьяалагдах бүрэлдэхүүн/салбар сургуулийн дансанд шилжүүлж олгоно.

## ДОЛОО. ТЭТГЭЛГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

- 7.1. МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг, докторын хөтөлбөрт суралцаж буй МУИС-ийн багшид олгох тэтгэлэг, докторын дараах судлаачийн тэтгэлэг, сургалт, судалгааны туслахын тэтгэлгийн тоо хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн хүрээнд МУИС-ийн захиргааны зөвлөл батална.
- 7.2. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн тэтгэлгийн төрөл, тоо хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн хүрээнд тухайн сургуулийн захирал батална.
- 7.3. Тэтгэлгийн санхүүжилтийн эх үүсвэр нь нээлттэй, тодорхой, улс төр, шашны үйл ажиллагааг сурталчлахад чиглэгдээгүй байх шаардлагатай.
- 7.4. Тэтгэлгийн хэмжээ, санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
  - 7.4.1. МУИС-ийн болон бүрэлдэхүүн/салбар сургуулийн төсөвт тусгагдсан өөрийн хөрөнгийн эх үүсвэр,
  - 7.4.2. Гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсийн хандив, тусламж,
  - 7.4.3. Бусад эх үүсвэр.
- 7.5. Тэтгэлэг олгогч байгууллага, хүмүүс нь тэтгэлгийн санхүүжилтийг суралцагчид шууд гардуулах, эсвэл МУИС-аар уламжлан олгож болно.
- 7.6. Тэтгэлгийн санхүүжилтийн хэлбэрээс шалтгаалан МУИС-аар уламжлан тэтгэлгийг олгох тохиолдолд шийдвэрийг МУИС-ийн ректорын тушаалаар баталгаажуулна.
- 7.7. Тэтгэлгээс суутгал тооцохгүй бөгөөд санхүүжүүлэгч тал санхүүжилтийг МУИС-ийн дансанд валютаар болон төгрөгөөр шилжүүлнэ. Валютаар хийсэн тохиолдолд тухайн өдрийн Монгол банкны валютын ханшаар хөрвүүлэн тооцож, тэтгэлэгт шалгарсан суралцагчид олгоно.
- 7.8. МУИС-ийн тэтгэлэгт хамрагдсан суралцагчийн илүү төлөлтөөс хувиараа төлсөн төлбөрийг буцаан олгох ба тэтгэлэгтэй холбоотой илүү төлөлтийг суралцагчид олгохгүй.

## НАЙМ. ТЭТГЭЛГИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ

- 8.1. Тэтгэлгийг үргэлжлүүлэн олгох эсэх нь тухайн тэтгэлгийн нөхцөл, шаардлагаас хамаарна.
- 8.2. Тэтгэлгийг үргэлжлүүлэн олгох тохиолдолд суралцагчийн сурлагын голч дүнгийн мэдээлэл болон холбогдох бусад материалыг оюутан хариуцсан нэгж нягтлан хянаж, баталгаажуулна.
- 8.3. Суралцагч хүндэтгэх шалтгааны улмаас чөлөө авсан тохиолдолд тэтгэлгийн төрлөөс хамаарч, тэтгэлгийг түдгэлзүүлж болно.
- 8.4. Тэтгэлэгт хамрагдсан боловч захиргааны болон гэмт хэргийн зөрчил гаргасан, бусад шалтгаанаар сургуулиас түр чөлөөлөгдсөн, сурлагын амжилт буурсан, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн зэрэг шалтгаанаар тэтгэлгийг үргэлжлүүлэн олгох боломжгүй нь тогтоогдсон тохиолдолд МУИС-ийн ректорын тушаалаар тэтгэлгийг цуцална.



## МУИС-ИЙН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛГИЙН ЖУРАМ

### НЭГ. ТЭТГЭЛГИЙН ЗОРИУЛАЛТ

- 1.1. МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг нь тус их сургуульд суралцаж буй бакалавр, магистр, докторын түвшний суралцагчдын сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, амжилттай суралцаж буй шилдэг суралцагчийг урамшуулах, зарим мэргэжлээр элсэгчдийг дэмжих зорилготой.
- 1.2. Хоёрдогч бакалаврын хөтөлбөрт суралцагчдад тэтгэлэг олгохгүй.
- 1.3. Хос мэргэжлээр суралцах тохиолдолд зөвхөн суурь мэргэжилд тэтгэлэг олгоно.

### ХОЁР. ТЭТГЭЛГИЙН ТӨРӨЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ШАЛГАРУУЛАХ

- 2.1. МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг нь дараах төрлүүдтэй байна. Үүнд:
  - 2.1.1. Олимпиадын нөхцөлөөр элссэн элсэгчийн тэтгэлэг
  - 2.1.2. Элсэлтийн шалгалтын өндөр үнэлгээгээр элссэн элсэгчийн тэтгэлэг
  - 2.1.3. Байгалийн ухаан, инженер салбарын хөтөлбөр сонгон элссэн суралцагчийн тэтгэлэг
  - 2.1.4. МУИС-д элссэн Монгол угсаатан гадаад иргэний тэтгэлэг

### ГУРАВ. ТЭТГЭЛГИЙН ШАЛГУУР, ХЭМЖЭЭ, ТЭТГЭЛЭГ ОЛГОХ

- 3.1. Суралцагчдад тэтгэлгийн батламжийг "МУИС-д суралцагчдад тэтгэлэг олгох ерөнхий журам"-ын 6.2-д заасны дагуу гардуулна.
- 3.2. Тэтгэлгийн төрлөөс хамааран шалгуур үзүүлэлт болон хэмжээ дараах байдлаар тодорхойлогдоно.
  - 3.2.1. Олимпиадын нөхцөлөөр элссэн элсэгчийн шалгуур: Улсын олимпиадад эзэлсэн байрыг нь харгалзан МУИС-д шинээр элсэгчид эхний хичээлийн жилийн тэтгэлгийг дараах харьцаагаар олгоно. Үүнд:
    - 3.2.1.1. I байр: сургалтын төлбөрийн 100 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг
    - 3.2.1.2. II байр: сургалтын төлбөрийн 75 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг
    - 3.2.1.3. III байр: сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг
    - 3.2.1.4. Олон улсын олимпиадад шагналт байр эзэлж, медаль хүртсэн элсэгчид улсын олимпиадын 1-р байранд шалгарсан суралцагчийнхтай ижил хэмжээний тэтгэлэг олгоно.
  - 3.2.2. Элсэлтийн шалгалтын өндөр үнэлгээгээр элссэн элсэгчийн шалгуур:
    - 3.2.2.1. ЭЕШ-ийн суурь болон дагалдах шалгалтад тооцуулсан дундаж

үнэлгээгээр 780 буюу түүнээс дээш оноо авч, Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбар болон Хүмүүнлэгийн ухааны салбар, Мэдээлэл технологи, электроникийн сургууль, Хууль зүйн сургууль, Бизнесийн сургууль, Улс төр судлал, Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуульд элссэн, 750 болон түүнээс дээш оноо авч, Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбар, Инженер технологийн сургуульд элссэн, Байгаль эх лицей сургуулиас элсэгчдийн хувьд суурь болон дагалдах шалгалтад тооцуулсан ЭЕШ-ын дундаж үнэлгээ 650 болон түүнээс дээш оноо авч, Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбар, Инженер, технологийн сургуульд элссэн бол эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг нэг удаа олгоно.

3.2.2.2. Төрөөс олгож буй тэргүүлэх болон эрэлттэй хөтөлбөрийн тэтгэлэгт хамрагдсан суралцагчид давхардуулж олгохгүй.

3.2.3. МУИС-д элссэн Монгол угсаатан гадаад иргэний шалгуур:

3.2.3.1 МУИС-ийн ахисан түвшний хөтөлбөрт элссэн монгол угсаатан гадаад иргэнд эхний улирлын сургалтын төлбөрийн 25 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг нэг удаа олгоно. Энд Засгийн газрын тэтгэлэг, оюутан солилцоо болон бусад тэтгэлэгт хамрагдсан суралцагчид хамаарахгүй.

3.3. Хичээлийн жилийн нэг улирлын сургалтын төлбөрийн хэмжээг тухайн хөтөлбөрийн бакалаврын түвшний хувьд 15 багц цаг, ахисан түвшний хувьд 9 багц цагийн төлбөрөөр тус тус тооцно.

3.4. Суралцагчийн тэтгэлгийг 1-р түвшний суралцагчийн хувьд ерөнхий суурь хичээлийн төлбөрөөр, бусад түвшний суралцагчийн хувьд харгалзах сургуулийн мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлийн төлбөрөөр тооцно. Ахисан түвшний суралцагчийн хувьд сургалтын багц цагийн (диссертацийн төлбөрөөс бусад) төлбөрөөр тооцно.

3.5. Тэтгэлэг авсан суралцагч тухайн хичээлийн жилд суралцагч чөлөө авсан тохиолдолд тэтгэлгийг цуцална. Бусад сургуульд шилжин суралцах тохиолдолд тэтгэлгийг буцааж төлнө.

\*\*\*\*\*

Ректорын 2025 оны 02 дугаар сарын 13-ны  
өдрийн А. тушаалын 03 дугаар хавсралт  
76



Ц.ДАМДИНСҮРЭН, Ш.ЛУВСАНВАНДАН, Б.РИНЧЕН  
НАРЫН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ

НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 1992 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу нэрт монгол судлаач Ц.Дамдинсүрэн, Ш.Лувсанвандан, Б.Ринчен нарын нэрэмжит тэтгэлэг олгоно.
- 1.2. Тэтгэлгийн зорилго нь монгол судлалын чиглэлээр ажилладаг гадаадын залуу судлаачдыг ахисан түвшний сургалтад хамруулж, мэргэшихэд нь дэмжлэг үзүүлэхэд оршино. Үүнд:
  - 1.2.1. Ц.Дамдинсүрэнгийн нэрэмжит тэтгэлэг - Монголын утга зохиол, түүх,
  - 1.2.2. Ш.Лувсанванданы нэрэмжит тэтгэлэг - Монгол хэл бичиг, эх бичиг судлал,
  - 1.2.3. Б.Ринчений нэрэмжит тэтгэлэг - Утга соёл, угсаатны зүй, хүн судлал.
- 1.3. Нэрэмжит тэтгэлгийг жилд тус бүр 1-2 хүнд олгоно.
- 1.4. Суралцагч сургалтын хугацаандаа МУИС-ийн дүрэм, бусад холбогдох журам, зааврыг мөрдөнө.

ХОЁР. НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГТ ХАМРУУЛАХ

- 2.1. Нэрэмжит тэтгэлэгт нэр дэвшигч нь монгол судлалын чиглэлээр докторантурт суралцагч болон докторын дараах судалгааны ажил хийх сонирхолтой 40 хүртэлх насны судлаач байна.
- 2.2. Суралцагч нь хичээлийн жилийн хугацаанд 3 сараар МУИС-д тодорхой хөтөлбөрийн дагуу ахисан түвшний сургалтад хамрагдаж, судалгааны ажил хийсэн байна.
- 2.3. Нэрэмжит тэтгэлгийн мэдээллийг Монгол судлалын хүрээлэн /МСХ/-ээс түгээнэ.
- 2.4. Нэрэмжит тэтгэлэгт нэр дэвшигч нь доорх материалыг бүрдүүлж, сургалтад хамрагдахаас 3 сарын өмнө МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнд ирүүлнэ. Үүнд:
  - 2.4.1 Боловсрол, ажлын туршлагыг илтгэх биеийн байцаалт (CV),
  - 2.4.2 Бүтээлийн жагсаалт,
  - 2.4.3 Суралцах зорилго, судалгааны хамрах хүрээг илтгэсэн өргөдөл,
  - 2.4.4 Мэргэжлийн профессорын тодорхойлолт,
  - 2.4.5 Суралцах хугацааны ажлын төлөвлөгөө,
  - 2.4.6 Эрүүл мэндийн үзлэгийн бичиг.
- 2.5. Монгол судлалын хүрээлэн нь тэтгэлгийн сонгон шалгаруулалтын мэдээллийг МУИС-ийн цахим хуудсанд байршуулна.



## ГУРАВ. ТЭТГЭЛЭГ ОЛГОХ, ШАЛГАРУУЛАХ



- 3.1. Тэтгэлэгт шалгарсан судлаачийн ажилд зөвлөх үүрэгтэй мэргэжлийн эрдэмтнийг зөвлөх профессороор томилж ажиллуулна.
- 3.2. Нэрэмжит тэтгэлэгт хамрагдах болзол хангасан судлаачид тэтгэлгийг олгоно. Үүнд:
  - 3.2.1. Оюутны байранд амьдрах нөхцөлөөр хангах,
  - 3.2.2. Сар бүр 700.000 төгрөгийн тэтгэлэг олгох,
  - 3.2.3. Орон нутагт судалгааны материал цуглуулах ажлаар явахад нэг удаа 300.000 төгрөгийн дэмжлэг үзүүлэх.
- 3.3. Тэтгэлгийн шалгаруулалтыг Эрдэм шинжилгээ, инновацын хэлтэс /ЭШИХ/-ийн төлөөллийг оролцуулсан Монгол судлалын хүрээлэнгээс томилсон ажлын хэсэг хариуцан зохион байгуулна.
- 3.4. Суралцагч суралцах хугацаандаа судалгааны семинарт идэвхтэй оролцох, илтгэл хэлэлцүүлэх, эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж хэвлүүлэх үүрэг хүлээнэ.  
Тэтгэлгээр суралцагч сургалт дуусахаас өмнө буюу сүүлчийн сарын тэтгэлгийг олгохоос өмнө судалгааныхаа ажлын тайланг мэргэжлийн тэнхимийн хурлаар хэлэлцүүлж, Монгол судлалын хүрээлэнд ирүүлнэ.

Ректорын 2025 оны ...02 дугаар сарын ...13... -ны  
өдрийн А/76 дугаар тушаалын 04 дүгээр хавсралт



## МУИС-ИЙН ДОКТОРАНТ БАГШИД ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

### НЭГ. ТЭТГЭЛГИЙН ЗОРИУЛАЛТ

- 1.1. МУИС-ийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 23.4 заалтыг хэрэгжүүлэх, МУИС-д үндсэн багшаар ажиллаж, тус сургуулийн докторын сургалтад амжилттай суралцаж буй багшид сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх хэлбэрээр энэхүү тэтгэлгийг олгоно.
- 1.2. Тэтгэлгийг докторын сургалтад элсэж, суралцвал зохих хугацаандаа тасралтгүй суралцаж, мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийг судалж, судалгаа шинжилгээний ажилд идэвхтэй оролцож, диссертацийн судалгаагаа хийж буй суралцагчид нэг удаа олгоно.
- 1.3. Тэтгэлгийг сургалтын төлбөрийн хөнгөлөлт хэлбэрээр, шууд бусаар олгоно.

### ХОЁР. ТЭТГЭЛЭГТ НЭР ДЭВШҮҮЛЭХ, ШАЛГАРУУЛАХ

- 2.1. Дараах нөхцөлийг хангасан докторант суралцагч энэхүү тэтгэлэгт нэр дэвших боломжтой.
  - 2.1.1. МУИС-ийн үндсэн багш байх,
  - 2.1.2. Докторын сургалтад элсэн судалбал зохих мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийг судалж багц цагаа бүрэн биелүүлсэн байх,
  - 2.1.3. Суралцагч мэргэжлийн судалгааны семинарт тогтмол оролцож, тэнхим, эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж, МУИС-ийн нэр дээр тухайн хөтөлбөрийн төгсөх шаардлагыг хангасан өгүүлэл хэвлүүлсэн байх,
  - 2.1.4. Суралцагч диссертацийн ажлаа бичиж дуусган тэнхимийн өргөтгөсөн семинараар хэлэлцэгдэн докторын зэрэг хамгаалуулахад бэлэн болсон байх.
- 2.2. Тэтгэлэгт тухайн суралцагчийн судалгааны ажлын удирдагч профессор багш тухайн хичээлийн жилийн 9 дүгээр сарын эхний долоо хоногийн дотор нэр дэвшүүлж, харьяа нэгжид хүсэлт гаргана.
- 2.3. Нэр дэвшигчдийг тэтгэлэгт хамруулах асуудлыг мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж дүгнэлт гарган, шаардлага хангасан тохиолдолд холбогдох бичиг баримтыг хурлын тэмдэглэл, шийдвэрийн хамт тухайн жилийн 9 дүгээр сарын 10-ны дотор Ахисан түвшний сургуульд хүргүүлнэ.
- 2.4. Ахисан түвшний сургуулиас тэтгэлэг олгох докторант багшийн жагсаалтыг нэгтгэн 09 дүгээр сарын 20-ны дотор МУИС-ийн Ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Ректорын тушаалаар баталгаажуулна.

## ГУРАВ. ТЭТГЭЛГИЙН ХЭМЖЭЭ

- 3.1. Тэтгэлгийг суралцагчид нэг удаа, дахин сунгах нөхцөлгүйгээр олгоно.
- 3.2. Докторант багшид олгох тэтгэлгийн хэмжээ нь диссертацийн ажлын багц цагийн 50%-тай тэнцүү байна.



## ДӨРӨВ. БУСАД

- 4.1. Тэтгэлгийг Багш нарын өдөр МУИС-ийн ректор гардуулна.
- 4.2. МУИС-ийн захирлын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/171 тушаалын 6 дугаар хавсралт дахь "Докторын сургалтад суралцаж буй МУИС-ийн багшид тэтгэлэг олгох журам"-ын хэрэгжилтийн хүрээнд өмнө нь тэтгэлэг авсан докторант багш нарт энэ журам хамаарахгүй.